

ААНУ  
2 АНАР

АДАЛ ЯВДАЛТ  
ЗУРАТ НОМ



Хүсэл үү?  
Хэрэгцээ юу?

## ӨМНӨХ ҮГ

Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд Монголбанкнаас санаачлан Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Санхүүгийн зохицуулах хороо хамтран хэрэгжүүлж буй Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд хүүхэд залууст санхүүгийн мэдлэг олгох зорилгоор цуврал комик номыг өргөн барьж байна. “Хүсэл үү, хэрэгцээ юу” анхдугаар цувралаас Та бүхэн мөнгө гэж юу вэ, мөнгөний үнэ цэнэ, хүсэл хэрэгцээ хоёроо хэрхэн ялгах вэ, зорилго мөрөөдөлдөө хүрэхэд хүч хөдөлмөрөөр олсон мөнгөө хэрхэн зөв зарцуулах, мөнгөө яаж үр дүнтэй өсгөж хуримтлуулах, мөнгөнд хандах хандлагаа өөрчилж илүү сайхан амьдрах боломжийг бага наснаасаа өөртөө хэвшүүлж сурх гээд санхүүгийн суурь мэдлэгийг энгийн, сонирхолтой хэлбэрээр хүлээн авч уншаарай.

Уншигч багачууд Та бүхэн энэхүү цувралаас хувийн санхүүгээ төлөвлөж, ирээдүйгээ харж, тооцоолох, хуримтлах эрмэлзэлтэй болсоор санхүүгийн боловсролтой иргэн болж хүмүүжихэд дэм болно.

МОНГОЛБАНК  
ОЛОН НИЙТИЙН БОЛОВСРОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

# Ану, Анар хоёртой танилцаарай

Нас: 14

Ам бүл: дөрөв (ээж, аав, эгч)

Хобби: дэлгүүр хэсэх

Дуртай хичээл: хими, математик, англи хэл

Мөрөөдөл: Ирээдүйд эмч мэргэжилтэй болох. Анартай танилцахаас өмнө ирэх жилийн мөрөөдлөө тодорхойлоогүй байсан.



Ану




Учрал

Нас: 19, оюутан  
Хобби: дэлгүүр хэсэх, чамин ад зүйлс цуглуулах



Аав, ээж



Аав, ээж

Нас: 14

Ам бүл: тав (ээж, аав, дүү нар)

Хобби: зураг зурах, ном унших, содон зүйл турших

Дуртай хичээл: шугам зураг, геометр, англи хэл, биеийн тамир

Мөрөөдөл: Ирээдүйд барилгын инженер мэргэжилтэй болох. Ирэх жил хүүхдийн зусландаамарч үзэх.




Анар

Аав, ээж



# 9 дүгээр сарын 1



Чи энд юу хийж байгаа юм.  
Багш даалгавар өгөөгүй  
биз дээ?


Тийм л дээ... Би дараа зун  
хүүхдийн зусландаа амрах  
мерөөдөлтэй болохоор  
төлөвлөгөө гаргах хэрэгтэй байна



## Анарын ирэх зуны мөрөөдөл

1. Зуслангийн төлбөр = 150 000 төгрөг
2. Сар бүр 15 000 төгрөг цуглуулах
3. Өдөр бүр 500 төгрөг хадгалах
4. 10 сарын дараа зуны зусландаа амрах

Яагаад заавал мөнгө цуглуулах гэж?  
Аав, ээж хоёроосоо мөнгө аваад  
зуслан явдаг шүү дээ







РС тоглохоо болж мөнгөө хурилтуулсан. Нэмээд аваа, эзж 2 сар бүрийн эцсэст 10 хувийн хүгийн урамшуулал үзүүлсэн.

Ингэж би 9 сарын турш мөрөөдлөө биелүүлэх хэмжээнд хүртэл мөнгөө хурилтуулж, унадаг дугуйтай болсон шүү дээ.

Яаж тэр вэ?





Анар аа, би чам шиг мөнггөө хүримтлупулж мөрөедлөө биелүүлэхээр шийдсэн.  
Чи надад туслах уу?

Гайхалтай.  
Би чамд туслахад бэлэн.  
Харин яж?



Би ч гэсэн чамтай адил зусланд амармаар байна.  
Тэхдээ өөрийнхөө хүримтлупулсан мөнггөөр шүү.

Тэгэлгүй яхав, хоёуулаа хичээлийн дараа номын санд суух, миний төлөвлөгөөгээ биелүүлнүү шүү.

Ану хичээл арт тарсан юм чинь явж дэлгүүр хэсэх уу?

За, тэгье охид оо.



Маргааш больб оо,  
Анар аа

Ану, чи төлөвлэсөн ажилтай шүү дээ.

Хичээлийн дараа







Чадалгуй дээ. Харин тэвчээртэй  
байхын тулд би юунаас эхлэх вэ?  
Надад зөвлөөч.

Т Э В Ч Э Э Р

Юу гээч Ану. Чи том  
мерреедэлдээ хүрэхийн  
тулд жижигхэн зориг,  
тэвчээр гаргаж чадах уу?

Найз нь чадахгүй ээ. Гэрийн  
даалгавараа хийх ёстой.

Анараа явж РС тогльё

Алив хурдан явж тогльё

Тэр үед чамд үнэхээр  
хэцүү байсан байх даа?

Тэр ч тийм шүү.  
Найзуудтайгаа уулзахаар  
РС хэрхэн гоё толгосон  
тухайгаа яриад л...

Би хүргэж өгөхүү?

Гэхдээ чи зориг, тэвчээр гаргаж, тэр  
бухнийг давж чадсан шүү дээ.  
За найз нь хариаас...

Пеах... тийм үү?  
Би заавал очноо.

Энэ удаад хэрэггүй дээ...  
Мартсанас маргааш миний  
терсэн одер хичээл тараад  
манайд ирээрэй.






Миний охины  
мерөөдөл юу  
юм бэ?

Заавал яагаад мөнгөө  
хуримтлуулж зуслан явах гэж?  
Аав, ээж хоёр нь чамд мөнгө  
өгч болно шүү дээ.


Ухаантай охиноо  
дэмжилгүй  
яах вэ дээ....  
Ямар дэмжлэг  
хэрэгтэй байна?



Дараа зун өөрийнхөө  
тогтол хуримтлуулсан  
мөнгөөрөө Анаартай  
цуг зуслан явах болно.  
Та хоёр зөвшөөрөх үү?



Охин нь заавал  
мөрөөдөлдөө хүрэхийн  
тулд тэвчээртэй  
байх болно. Харин  
та хоёр  
намайг дэмжээрэй





Яриа дундуур нь зөвшөөрөлгүй оролцсонд уучлаарай.

Ану өдөр бүр авч иддэг амттанаасаа татгалзаж, үүнд зарцуулдаг мөнгөө тогтмол цуглуулж, өмнөө тавьсан мөрөөдөлдөө өөрийн чадлаар хүрч чадна гэдгээ гэр бүл, наиз нөхдийнхөө өмнө харуулахыг хүсч байгаа юм.

Миний охин хуримтлуулсан мөнгөнийхөө 10 %-ийн хүүг аав ээжээсээ марталгүй авч байгаарай

•Мөрөөдлийн хайрцаанд минь цугласан мөнгөнд 10%-ийн хүү тооцож, урамшуулж байн Хагас, бутан сайн өдруүдэд тогтмол 1000 төгрөг егч байх, хуримтлуулсан мөнгөөрөө ирэх зүн Анартал цуг зуслан явахыг минь зөвшөөрөх Зөвшөөрсөн  
Аав..... Ээж.....



Ээж нь хувьдаа зөвшөөрч байна.  
Ээж нь гарын үсгээ зурчихъя

Баярлалаа.  
Аав, ээж та  
хоёртоо хайртай  
шүү





Юмны үнэ өсч, буурч байдгийг  
миний эдийн засгийн ангид  
сурдаг оюутан охин  
маань арай мэддэггүй  
юм биш биздээ?



Хэрэв мөнгө нь дутвал  
ээж нь өгнөө.

Мэдэлгүй дээ. Хэрэглэдэг  
зүйлсийн маань үнэ өсөхийг  
ерөнхийд нь Инфляци гэдэг.  
Хичээл дээрээ заалгасан юм.



Тэгвэл энэ жил 150000 төгрөгний  
үнэтэй байсан зуслангийн эрхийн  
бичгийн үнэ ирэх жил өсөх нь ээ?




Тийм шүү. Манай аав, ээж хоёр ч гэсэн тантай адилхан бодолтой байдаг.

Одоогоор миний найз нар дунд лав байхгүй л байна.

Сүүлийн үед юмны үнэ тогтворжиж байгаа болохоор миний хоёр хүү битгий санаа зовдоо. Хэрэв мөнгө нь дутвал аав нь биш ээж нь өгнө гэлээ шүү дээ.

Анараа, миний охинд зөв, сайнаар нөлөөлж байгаа чамд баярлалаа. Мөнгөө хуримтлуулж, мөрөөдлөө биелүүлдэг чам шиг хөвгүүд танай найз нар дунд олон бий биз?



Мөнгөө зөв зарцуулж байгаа хүүхдүүдээ дэмжилгүй яах юм.



Хүүхдүүд мөнгөө цуглуулж яах юм бэ?  
Би өдөр дэлгүүрт загвар  
сайтай, яг миний сонирхдог цамц  
өмсөж үзсэн. Тэрийг л авмаар байна.




Аав нь цалин  
буухаар охиндоо  
авч өгье. Тэгэх үү?

Үгүй ээ... Тэр цамц зарагдчихвал  
яах юм бэ? Цорын ганц байгаа гэсэн



Чи чинь саяхан ээжээрээ шинэ  
цамц авахуулсан биз дээ?  
Тэрийгээ ер өмсөж харагдахгүй юм.





Тэр цамцтай чинь яг адилханыг манай  
ангийн охин өмчихсөн байна билээ.  
Яаж би тэр охинтой адилхан цамц өмсөх юм бэ?

За яахав. Чи дүү шигээ  
тогтмол хуримтлал  
үүсгэж чадна гэвэл  
би тэр цамцыг нь авч өгье.  
Харин чадахгүй бол 3 сар  
шинэ хувцас худалдан  
авна гэж бүү санаарай.  
Болж байна уу?

Тэгье. Ёстой амархан. Би ер нь  
банкинд хадгаламжтай болъё  
гэж аль эртнээс бодоод байсан юм.  
Тэгээд мөнгөө хийгээд л гүйцээ.





Би харьж гэрийн даалгавраа  
хийгээд, дүү нараа цэцэрлэгээс нь авах  
ёстой. Сайхан хоол, амттанаар  
дайлсан та бүхэнд баярлалаа

Төрсөн өдөрөөс  
хойш нэг сарын дараа

Өөрийн хуримтлуулсан  
30000 ₮, авв ээж  
хоёр өмнөх сарын хүүг  
тооцож өгсөн.  
Нийт 31500 ₮

Чиний мөрөөдлийн  
хайрцагт хэдэн төгрөг  
хуримтлагдсан бэ?  
Тоолсон уу?

Хөөх... Чи өдөр бүр  
хуримтлуулж чаджээ.  
Маш сайн байна.

Анаар аа миний мөрөөдлийн  
хайрцагт хэдэн төгрөг  
хуримтлагдсан гээч,  
чи лав итгэхгүйдээ...









Зуны амралт  
эхэллээ, Ура..



Зуслан явах  
мөрөөдөл  
маань ойртоор...

Тэгье, тэгье. Долдугаар  
сарын эхээр хамтдаа  
бэлдэж эхлэх үү.

Хоёулаа  
зуслангийн  
бэлтгэлээ  
хамтдаа  
хийх үү?



Энэ жилийн зуслангийн  
эрхийн бичгийн  
үнэ битгий  
нэмэгдчихсэн байгаасай.

Харин тийм ээ... Гэхдээ хоёуланд нь  
мөнгө дутвал ээж дэмжлэг  
үзүүлнэ гэж амласан шүү дээ.  
Санаж байгаа биз.

Мхмм...

Би лав санаа  
зовохгүй байнаа.  
Миний мөрөөдлийн  
хайрцагт хуримтлагдсан  
мөнгө хангалттай  
хүрнэ гэж бодож байна

Тийм дээ, хоёулаа хуримтлал  
үүсгэж чадсан юм чинь  
юундаа ч санаа зовох юм бэ дээ.

Авч явах зүйлс чинь бүрэн биз?  
Дахиж сайн нягтлаарай За, за бүрэн байгаа.  
Санаа зоволтгүй дээ. 7:30-д уулзажгаая. Түр баяртай.

Чи яаж унтаж чадаж байнаа?  
Би лав 10 сар хүлээсэн  
мерөөдөл минь өнөөдөр биелнэ  
гэж бодохоор нойр хүрсэнгүй.

Байна уу Ану, сэrsэн үү?

Хэхэ... Ямар  
их догдлол вэ?  
Тайван байл даа.

Ммм... Ямар эрт залгаж  
байнаа. Сая сэрлээ.

Би ч гэсэн энэ хоёр шиг мэнгээ  
хуримтуулж чадах юм чинь.  
Харин яаж эхлэх вэ байз???

Аав, ээж нараа амрах  
хугацаанд эргэж ирээрэй.

Сайхан амраад олон найз,  
нөхөдтэй болоод ирээрэй,  
хүүхдүүдээ. Гол, уснаас хол  
байгаарай. Наршиж,  
даарваа, Сайн яваагай  
хүүхдүүдээ.

# Хүүхдүүдээ, Ану, Анаар хоёрын цутглуулсан мөнгө хэд болсон бэ?

**Сар**

**Ану**

Өөрийн  
цутглуулсан

Аав ээжийн  
урамшуулал  
(10%)

Нийт

**9**

**Цутглуулж эхлээгүй байсан**

**10**

**11**

**12**

**1**

**2**

**3**

**4**

**6**

**7**

**Анаар**

Өөрийн  
цутглуулсан

Аав ээжийн  
урамшуулал  
(10%)

Нийт


# Мөнгөө цутгуулж, мөрөөдлөө биелүүлэх 5 алхам

1

Бид 2 шигт мөрөөдлөө тодорхой болгоорой!



2

Анаар шигт мөнгөө цутгуулах бодитой  
төлөвлөгөө гаргаарай!



3

Ану шигт “мөрөөдлийн хайрцаг”-тай  
боловорой



4

Аав, ээжээсээ авдаг мөнгөнөөсөө эхлээд  
“Мөрөөдлийн хайрцаг”-таяа хийж сураарай.  
Үлдсэнээ үргж болно.



5

Сар бурийн эцэст аав, ээжээсээ мөрөөдлийн  
хайрцатныхаа мөнгөн үлдэгэлд хүү  
тооцуулж байгаарай

10%



## ОЛОН НИЙТИЙН САНХҮҮГИЙН СУУРЬ МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР



БОЛОВСРОЛ,  
СӨӨЛ,  
ШИНӨКЛЭХ УХДАНЫ ЯМ



САНГИЙН ЯМ



САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО



Худалдан борлуулахыг хориглоно.